



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дархан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 21 нэрийн, нийт 223,915,114.64 (хоёр зуун хорин гурван сая есөн зуун арван таван мянга нэг зуун арван дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 69,590,843.16 (жаран есөн сая таван зуун ерэн мянга найман зуун дөчин гурван төгрөг арван зургаан мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001160

15-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАН АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХӨРТӨГГҮЙ,
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Усны машин камаз ДАР 48-71	2009-09-03	1	160,295,111.00	160,295,111.00	48,088,533.30	3
2	Хийн доргиурт индүү ДА 90-34	2009-09-03	1	39,456,916.00	39,456,916.00	11,837,074.80	3
3	Хөлдөөгч 102 литр	2017-05-25	1	235,454.55	235,454.55	94,181.82	2
4	Принтер Epson А3	2020-01-22	1	2,499,909.09	2,499,909.09	999,963.64	2
5	Автомат алх	2012-11-01	1	1,818,182.00	1,818,182.00	727,272.80	4
6	Багаж	2012-11-30	1	2,727,273.00	2,727,273.00	1,090,909.20	4
7	Бетон пресс	2012-11-01	1	5,909,090.00	5,909,090.00	2,363,636.00	4
8	Бетоны суулт хэмжигч	2012-11-01	1	136,364.00	136,364.00	54,545.60	4
9	Бетоны шооны хэв	2012-11-01	1	31,818.00	31,818.00	12,727.20	4
10	Бюкс жижиг	2012-11-01	1	18,180.00	18,180.00	7,272.00	4
11	Маршаллын пресс бш хэв алх	2012-01-01	1	4,090,909.00	4,090,909.00	1,636,363.60	4
12	Проктерийн алх 2,5	2012-11-01	1	318,182.00	318,182.00	127,272.80	4
13	Стантарт элс	2012-11-01	1	72,728.00	72,728.00	29,091.20	4
14	Термометр лазер	2012-11-01	1	63,636.00	63,636.00	25,454.40	4
15	Термометр электрон	2012-11-01	1	72,727.00	72,727.00	29,090.80	4
16	Усан ванн	2012-11-01	1	909,090.00	909,090.00	363,636.00	4

17	Хатаах зуух	2012-01-01	1	909,090.00	909,090.00	363,636.00	4
18	Хувийн жин тодорхойлогч	2012-11-01	1	836,364.00	836,364.00	334,545.60	4
19	Шатаах зуух	2012-11-01	1	2,727,273.00	2,727,273.00	1,090,909.20	4
20	Шимтдийн алх шалгагч	2012-11-01	1	468,636.00	468,636.00	187,454.40	4
21	Электрон жин 3кг	2012-11-01	1	318,182.00	318,182.00	127,272.80	4
	Нийт дүн		21		223,915,114.64 (хоёр зуун хорин гурван сая есөн зуун арван таван мянга нэг зуун арван дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө)	69,590,843.16 (жаран есөн сая таван зуун ерэн мянга найман зуун дөчин гурван төгрөг арван зургаан мөнгө)	